

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр, Даваа гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 0

Хуралдааны товч тэмдэглэл: 1-7

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

-
- | | |
|---|------------|
| 1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/ | 9 |
| 2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонголын бэлтгэл хангах тухай/ | 9-11 |
| 3.Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 11-13 |
| 4.Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 13-14 |
| 5.““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл | 14-32 |
| 6.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал 2019.02.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ | хойшлуулав |

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 18 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 17 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Ганибал, Ц.Даваасүрэн;
Чөлөөтэй: Б.Жавхлан, Д.Өнөрболор, О.Цогтгэрэл.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан үг хэлж, Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх асуудлыг хойшлуулав./14:20/

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ц.Цэрэнпунцаг: “Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Батгөмөр, Н.Ганибал, Т.Доржханд, Ч.Ундррам нар ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын бэлтгэл хангах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Ц.Цэрэнпунцаг: “Нэр дэвшигчийн сонсголын бэлтгэл хангах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 2
Бүгд: 12
83.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Х.Итгэлт, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн

найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Х.Итгэлт хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Х.Итгэлт, Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хороо

хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргав.

Ц.Цэрэнпунцаг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ц.Цэрэнпунцаг: Горимын санал дэмжигдсэн тул Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 1

Бүгд: 12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Тав. *““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Салбарын бодлого зохицуулалтын газрын Засгийн газрын референт Д.Нямдэлгэр, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Төгөлдөр, Санхүүгийн зохицуулах хорооны Хуулийн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, “Эрдэнэс-Монгол” ХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Л.Батмөнх, Байнгын

хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн зөвлөх Ж.Бямбадулам нар байлцав.

Төслийн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, төслийн талаарх Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсээс гаргасан хууль зүйн дүгнэлтийг Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар нар танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулга болон хууль зүйн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Ч.Ундрэм, Д.Батлут нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, “Эрдэнэс-Монгол” ХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар нар хариулж, тайлбар хийв.

““Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Т.Доржханд, Ч.Ундрэм, Т.Энхтүвшин, М.Оюунчимэг, Х.Ганхуяг нарын /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ гаргасан, 1. Тогтоолын төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын нийт иргэдэд адил тэнцүү хэмжээгээр эзэмшүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1/2012 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн 1072 ширхэг энгийн хувьцааг эзэмшүүлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2/Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүйгээр олгосон “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааг тус компанийн энгийн хувьцаанд бүртгэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3/“Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн эрх бүхий этгээд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, “Эрдэнэс Монгол” нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хооронд үүссэн өр авлагад суутган тооцох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн тавьсан асуултад “Эрдэнэс-Монгол” ХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Тогтоолын төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтыг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 2
Бүгд: 11
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 31 минут үргэлжилж, 18 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувийн ирцтэйгээр 15 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим,
14 цаг 17 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Цэрэнпунцаг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн нэрсийг танилцуулъя. Наянтайн Ганибал гишүүн орон нутагт ажиллаж байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн гадаадад томилолттой. Ингээд бусад гишүүд хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 55.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2024 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг.

2. “Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах бэлтгэл хангах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах талаар.

3. Төмөр замын тээврийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх

журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2024 оны 01 сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.

4. Иргэний нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2024 оны 01 сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.

5. “ЭТТ хувьцаат компанийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Засгийн газар 2023 оны 12 сарын 20-ны өдөр нэн яаралтай өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.

6. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Учрал 2019 оны 2 сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.

Ийм 6 асуудал хэлэлцэхээр байна. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Баттөмөр гишүүн танд микрофон өгье дөө. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн ажлын хэсгийг ахалж байгаа. Энэ өнөөдрийн Байнгын хорооны хуралд хэлэлцэх ийм боломж байна уу, та тайлбар өгөх үү.

Б.Баттөмөр: Энэ мэргэжлийн нэгдсэн холбооны хууль дээр бид нар нэлээн сайн ажиллалаа. Тэгээд анхны оруулсан саналаас 50 орчим хувийг нь зарчмын зөрүүтэй санал гарч байгаа. Тэгэхдээ ажлын хэсгийн гишүүд ярилцаад нэгдсэн дүгнэлтэд хүрч чадсангүй. Тийм учраас бэлтгэл хангагдаагүй учраас өнөөдрийн Байнгын хорооны хуралдааныг хэлэлцэх асуудлаас хасаж өгөөч гэсэн саналыг тавьж байна.

Ц.Цэрэнпунцаг: Өнөөдрийн хэлэлцэх асуудлын 6 дугаарт тавигдсан Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцүүлгийг өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудлуудаас хаслаа.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудал.

Нэг. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Та бүхэндээ төслийг уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

Нэг. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Т.Энхтүвшин Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүдэд: Б.Баттөмөр Улсын Их Хурлын гишүүн, Н.Ганибал Улсын Их Хурлын гишүүн, Т.Доржханд Улсын Их Хурлын гишүүн, Ч.Ундрам Улсын Их Хурлын гишүүн.

Хоёр. Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн тусалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын мэргэжлийн албан хаагчдыг ажиллуулахыг ажлын хэсэг /Т.Энхтүвшин/-т зөвшөөрсүгэй.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Санал хураалт явуулж эхэлье. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Гишүүдийн 91.7 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж уншаагүй болохыг протоколд тэмдэглүүлэв.

14.22 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр.Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах бэлтгэл хангах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Төслийг уншиж танилцуулъя.

Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйл, Төрийн албаны тухай хууль шинэчилсэн найруулгын 43 дугаар зүйл, Төв банк, Монголбанкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2. 4 дэх хэсгийг тус

тус үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь:

1.Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах бэлтгэл хангаж, нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулга болон тус албан тушаалд тавигдах нийтлэг тусгай шаардлагыг тусгасан мэдээлэл авах маягтын загвар боловсруулахыг Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцагт даалгасугай.

2.Хууль тогтоомжоор эрх олгогдсон этгээд Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийг санал болгож, тухайн албан тушаалтан томилогдох хүртэл хугацаанд холбогдох хуульд заасны дагуу Монгол банкны дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайванаар Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгүүлсүгэй.

Төсөлтэй холбогдон холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Чинзориг гишүүнээр тасаллаа. Чинзориг гишүүн асуултаа асууж, саналаа хэлье.

С.Чинзориг: Энэ тогтоолын 2 дахь заалт нь би буруу ойлгож байгаа юм болов уу. Манай энэ ажлын албаныхан энэ хуульчид харсан юм болов уу. Эдийн засгийн байнгын хорооны тогтоолоор Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүргийг одоогийн албан тушаал хашиж байгаа дэд ерөнхийлөгчөөр нь түр орлон гүйцэтгүүлсүгэй гэж ингэж тогтоол гардаг чинь Байнгын хороонд ийм эрх, хэм хэмжээ, ийм зохицуулалт байгаа билүү? Энэ Байнгын хорооны тогтоолоор би ингээд нэг ажиллаж байгаа орон тооны дэд ерөнхийлөгч нь орон гарсан тэргүүн дэд ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгүүлсүгэй гэдэг чинь Байнгын хорооны тогтоолоо шийдэх асуудал ч арай биш болов уу гэж бодох юм даа. Үүнийгээ яаж зохицуулах

юм бол доо. Үгүй бол Их Их Хурлын даргын захирамж гарах юм уу? Байнгын хороонд ийм эрх хэмжээ мэдэл байгаа юм уу? Үүнийгээ манай ажлын албаныхан, хуульчид харсан юм байгаа биз дээ. Би бол жсоохон эргэлзээтэй л байна даа.

Ц.Цэрэнпунцаг: Чинзориг гишүүний бас анхааруулж байгаа анхааруулга бол бас үндэслэлтэй. Тэгэхдээ яг энэ өнөөгийн нөхцөл байдал дээр энэ Монголбанкны дэд ерөнхийлөгчийг сонгон шалгаруулах энэ хугацаанд бол ажил завсардаад байгаа юм. Ялангуяа өнөөдөр энэ Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгч бол албан тушаалаараа хадгаламж даатгалын корпорац мөнгөний бодлогын хороонд ордог. Дээрээс нь өнөөдөр бид нарт бодит байдал ямар байдалтай байгаа вэ гэхээр, Банкны хууль хугацаа сунгагдаагүй байна. Ийм учраас бол өнөөдрийн байдлаар энэ банкнууд дээр Монголбанкнаас хяналт шалгалт хийх ажил бол эрчимжих ёстой. Яагаад гэвэл, хувьцаа эзэмшигчдийн 20 хувиас дээших хувьцаанууд бол саналын эрхгүй болох ийм нөхцөл байдал үүссэн. Үүнийг Монгол банкнаас зохицуулах ийм шаардлага гарч байгаа учраас энэ Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчийн ажлын чиг үүрэгт Монголбанкны хяналт шалгалт хийх ажлыг хариуцдаг учраас бол үүнийг эзэнжүүлье гэж ингэж оруулж ирсэн.

Өнөөдрийн байгаа хуулиуд дээр энэ завсардал гарч байгаа хугацаанд ямар нэгэн зохицуулалт байхгүй учраас Байнгын хорооны тогтоол дээр 2 дахь зүйл заалтаар энэ хугацаанд энэ албан тушаалыг дэд ерөнхийлөгчөөр нь хавсран түр орлон гүйцэтгүүлье гэсэн ийм агуулгатай гаргаж байгаа юм. Чинзориг гишүүн тодруулж асууя.

С.Чинзориг: Яах вэ, тэр ажлын шаардлага, хэрэгцээ байгааг нь ойлгож л байна. Гэхдээ тэгээд хуулиар ийм Байнгын хороонд олгогдоогүй эрхийг Байнгын хороо тогтоолоор ингэж

шийдэж болохгүй шүү дээ. Хуулиар Байнгын хороонд ийм томилгоо хийх, түр орлон гүйцэтгэх, томилох ийм эрх хууль Байнгын хороонд бол байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ чинь хуулиар олгогдоогүй эрх мэдлийг бид нар Байнгын хорооны тогтоол хийж болохгүй ээ. Тэр ажлын шаардлага байгааг нь ойлгож байна. Гэхдээ ажлын шаардлага байгаа ч гэсэн Байнгын хороо хуулиар олгогдоогүй эрх эдлээд, тэгээд бүүр томилгоонд оролцсон юм шиг байдлаар орчихлоо шүү дээ. Түр орлон гүйцэтгүүлсүгэй гээд. Байнгын хороогоор хэзээ тогтоолоор томилгоо хийж байсан юм. Тэгээд энэ болохгүй шүү дээ. Үүнийгээ энэ хуульчид жаахан чиглэл өгөхгүй бол сүүлд нь энэ чинь.

Тэгэхдээ Байнгын хороонд ийм ийм эрх хэмжээ байхгүй. Томилж байна гэсэн үг шүү дээ.

Ц.Цэрэнпунцаг: Энэ 7 хоногт намрын чуулган хаах гээд байдаг. Тэгээд Их Хурлын тогтоол уг нь гаргачихъя гээд бодож байсан. Тэгээд энэ хугацааны хувьд бол амжихгүй болоод байгаа юм. Тэгээд ямар ч байсан ингээд намрын чуулган завсарлахаас өмнө бол бид нар энэ албан тушаалыг ингэж эзэнгүй орхигдуулж, Монголбанкны энэ хяналт шалгалт хийх ч ажил үүргээ ингэж хөсөрдүүлж болохгүй гэдэг үүднээс үүнийг оруулж байгаа юм. Бас тэгээд хуулийнхантайгаа зөвлөсөн, ярилцсан, тэгээд иймд хууль зөрччихсөн юм бол энд байхгүй юм байна билээ.

Ийм учраас энэ тогтоолын төслийг ийм 2 зүйл заалттай бэлдсэн юм байгаа юм.

Санал хураалт явуулж эхэлье. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа.

Ингээд санал хураалт явуулж эхэлье. Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах бэлтгэл хангах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя

гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Гишүүдийн 83.3 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах бэлтгэл хангах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцүүлэг дууслаа.

14.29 цаг

Ингээд дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 3.

Гурав.Төмөр замын тээврийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийг оруулна уу. Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. С.Болд-Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ч.Мөнхтуяа ИНЕГ-ын дарга, Х.Итгэлт ЗТХЯ-ны Төмөр зам далайн тээврийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, С.Мяндасмаа ЗТХЯ-ны Хуулийн хэлтсийн дарга.

Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү?

Ж.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

Ж.Бат-Эрдэнэ: Сая 1 тогтоол гарлаа шүү дээ. Чинзориг гишүүний хэлээд байдаг чинь бас үнэн л дээ. Монголбанкны дэд ерөнхийлөгчийг түр орлон гүйцэтгүүлсүгэй гээд гарчихдаг. Үүнийг эргэж харвал харахаар л тогтоол. Яг үүнтэй адилхан гэнэт бас

нэг юм толгойн дотор юм орчих юм. Энэ хугацаа сунгаж байгаа тийм үү? Хугацааг сунгахынхаа оронд харин хуульд өөрчлөлт оруулаад, яамны эрх мэдлийн, сайдын эрх мэдлийн хүрээнд зарим асуудлуудыг шилжүүлээд энэ хуулийг хэрэгжүүлсүгэй гэсэн юм гарч болохгүй байсан юм уу? Тэгвэл наад хууль чинь цаг хугацаа хойшлохгүйгээр хэрэгжээд ингээд явчхаж байгаа.

Яг үнэндээ Төмөр замын хуулийг хойшлуулжгүй хууль. Бид өнөөдөр яриад л байдаг, юмны үнэ өслөө л гээд байдаг. Орж ирж байгаа төмөр замын өөрөөр хэлбэл тээврийн асуудал нь ингээд зөндөө том проблемууд байна шүү дээ. Үүнийг шийдэх гэж л бид нар энэ Төмөр замын хуульд өөрчлөлт оруулаад энэ олон тээвэрлэгчдийн хоорондын харилцаа холбоог сайжруулах, гүйцэтгэлийг нь сайжруулах, бараа таваарын эргэлтийг сайжруулах гээд өчнөөн олон зүйл дээр л шинэчлэл ирж байгаа хууль шүү дээ уг нь. Бүтэн жилээр хойшлуулмааргүй хууль байгаа юм. Тийм болохоор сая гэнэт орж ирэх юм. Тийм санал бас байж болохгүй л байсан юм байх даа. Сайдын эрх үүргийн хүрээнд зарим нэгэн заалтыг оруулаад ингээд явсан бол хэрэгтэй л байх байсан юм даа. Тэгээд хэн ч хариулах юм.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс хариулах уу. Саяын Ж.Бат-Эрдэнэ гишүүний гаргаж байгаа томъёоллоор ингээд явчхаж болоогүй юм уу гэж байна. Ажлын хэсгийн 3 номер хариульга.

Х.Итгэлт: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. ЗТХЯ-ны Төмөр зам далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Итгэлт. Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариульга. Тэгээд 8 сард бид нар Засаг руу агентлагаа оруулаад хойшлоод тэгээд хууль хойшлох юм байна гэдэг ойлголттой яваад нөгөө суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч, салах зэрэг бусад нөгөө процессын ажлуудаа бүгдийг нь хойшлуулчихсан байгаа. Тэгэхээр ганцхан агентлаг байгуулахгүй,

яам руу эрх үүргээ шилжүүлсэн ч гэсэн бусад нөгөө бид хэдийн гүйцэтгэх дүрэм журам компаниуд салах ингээд бэлтгэл ажлуудыг бүгдийг нь хойшлуулчихсан байгаа учраас энэ дээр бас хийдэл гарчих болов уу гэсэн ийм бодолтой байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж дууслаа. Төмөр замын тээврийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан саналтай гишүүд байна уу? Саяынх үг авсан, асуулт авсан. Алга байна. Санал хэлэх гишүүн алга байна.

Ингээд Төмөр замын тээврийн тухай хууль Шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Гишүүд асуулт асууж дууслаа. Төмөр замын тээврийн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдээс санал гараагүй тул төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргаж байна.

Тэгээд горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуульга.

Санал хураалт. Гишүүдийн 83.3 хувь нь дэмжлээ.

Мөн Батлут гишүүний саналын аппарат ажиллахгүй байх шиг байна. Дэмжиж санал өгсөн протоколд тэмдэглээрэй. Та картаа солиод хийгээд үз дээ.

Ингээд гишүүдийн 83.3 хувь нь дэмжиж санал дэмжигдсэн тул Төмөр замын тээврийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хууль Шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Гишүүдийн 91.7 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Мөн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин танилцуулна.

Төмөр замын тээврийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төмөр замын тээврийн тухай хууль Шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

14.36 цаг

Ингээд дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 4.

Дөрөв.Иргэний нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн нэрсийг танилцуулъя. Түрүүн танилцуулсан адилхан ажлын хэсэг байгаа. Ингээд Иргэний нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй

холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Гишүүд асуулт асууж дууслаа.

Иргэний нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдээс санал гараагүй тул төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргаж байна. Горимын саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Гишүүдийн 83.3 хувь нь дэмжлээ.

Батлут гишүүний карт ажиллахгүй байна шүү. Батлут гишүүн дэмжиж саналаа өгсөн.

Ингээд горимын санал дэмжигдсэн тул Иргэний нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсгийг үндэслэн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. Гишүүдийн 91.7 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин танилцуулна.

Иргэний нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

14.38 цаг

Дараагийн асуудалдаа орѐе.
Хэлэлцэх асуудал 5.

Тав. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр танилцуулна. Гишүүний микрофоныг нээе.

Б.Баттөмөр: Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тавантолгойн ХК-ийн хувьцааны талаар авах арга хэмжээний Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний 214 тоот захирамжаар хэлэлцэх асуудлын тов дарааллыг харгалзахгүйгээр Улсын Их Хурлын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр тогтсон.

Тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Эдийн засгийн байнгын хороо Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаарх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар байгуулж ахлагчаар нь Улсын Их Хурлын Баттөмөр, гишүүдэд Ганхуяг, Доржханд, Ундрэм, Цогтгэрэл, Энхтүвшин нар ажиллалаа.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох тогтоолын дагуу Эрдэнэс Тавантолгой компанийн гаргасан хувьцааны Эрдэнэс Монгол компани 81.5 хувийг, 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс өмнө төрсөн 2.5 сая иргэд 18.5 хувийг, 486 үндэсний ААН-үүд 0.06 хувийг тус тус эзэмшиж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн байгалийн баялгийн үр өгөөжөөс иргэд бүрд тэгш хүртээмжтэй олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Эрдэнэс Тавантолгой компанийн хувьцааг 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн болон харьяат орсон иргэдэд хэрхэн эзэмшүүлэх, Монгол Улсын иргэдэд олгосон хувьцааг энгийн хувьцаанд бүртгэх ийм шаардлага үүсээд байна.

Тогтоолын төсөл батлагдсанаар байгалийн баялгийн үр өгөөжөөс иргэн бүр тэгш хүртэх боломжтой болоод зогсохгүй Эрдэнэс Тавантолгой компанийн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналт оролцоо дээшилж, ил тод нээлттэй компанийн засаглал хөгжихөд ач холбогдолтой.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүгдээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Цэрэнпунцаг: Баттөмөр гишүүнд баярлалаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.27 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын төсөлд хийсэн эрх зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль

эрх зүйн газрын дарга Н.Мягмар танилцуулна. Мягмар даргын микрофоныг нээе.

Мягмар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль эрх зүйн газрын дарга Мягмар.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн шийдвэр болон Улсын Их Хурлын Тамгын газарт 2024 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр ирүүлсэн УИХ 14/27 тоот албан бичгийг тус тус үндэслэн гаргасан хууль зүйн дүгнэлтийг танилцуулъя.

Хууль зүйн дүгнэлтийн хүрээ хязгаар гэдэг хэсгээс эхэлье. Хууль зүйн дүгнэлт гаргахад Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалд тусгагдсан тус компанийн нийт хувьцааны 34 хувьд багтаан Монгол Улсын иргэдэд 1072 ширхэг хувьцаа эзэмшүүлэх болон нас барсан иргэнийг хувьцаа эзэмшигчийн бүртгэлээс хасах тухай зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль Иргэний хуульд заасан иргэний өмчлөх эрхийг хөндөж байгаа эсэх иргэдэд эзэмшүүлэх 1072 хувьцаа эзэмшлийн зохицуулалт нь Компанийн тухай хуулийн холбогдох зүйл хэсэг заалтуудад нийцэж байгаа эсэх талаар эрх зүйн дүгнэлт гаргуулах тухай Эдийн засгийн байнгын хорооноос өгсөн чиглэлийг үндэс болгосон болно.

1. Үндсэн хууль бусад хуульд нийцэж байгаа эсэх хэрэгжих боломжийн талаар.

Төсөл санаачлагчаас тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн байгалийн

баялгийн үр өгөөжөөс иргэн бүрд тэгш хүртээх боломжийг олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор боловсруулсан гэжээ. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх тэгш шударга хүртээхэд чиглэнэ.

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэсэн зохицуулалт зөрчигдөх эрсдэлтэй байгааг анхаарах шаардлагатай байна.

2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг гол хэсэг нь бүх ард түмний мэдэлд байх байгалийн баялгийг ашиглах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох одоо ба ирээдүй үеийн нийтлэг ашиг сонирхлын төлөө олон нийтийн хяналтын доор зөв оновчтой удирдаж хүн амын амьдралын нөхцөлийг сайжруулахад үр дүнтэй төлөвлөн ашиглах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн бөгөөд газрын хэвлий түүний баялаг төрийн нийтийн өмч болохыг Үндсэн хуульд тусгайлан заасан нь хүнээс хамааралгүй бий болсон байгалийн нөхөн сэргээгдэхгүй нөөцийг зөвхөн өнөөгийн Монгол улсын иргэд ашиглаад дуусгах бус ирээдүй үр хойчдоо үлдээх буюу үр шимийг нь төрийн урт хугацааны бодлогоор хуульд заасны дагуу бүх ард түмэн нийтээрээ тэгш шударгаар хүртэх боломжийг олгох зорилготой юм.

Тогтоолын төсөлд Монгол Улсын иргэн бүрд адил тэнцүү хэмжээгээр үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх нийт хувьцааны хувь хэмжээг нэмэгдүүлэн компанийн нийт хувьцааны 34 хувийг Монгол Улсын иргэн бүрд адил тэнцүү хэмжээгээр эзэмшүүлэхээр тогтоохдоо одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолд заасан нөхцөлөөр 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн Монгол Улсын 944.8 иргэнд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 1072 хувьцааг эзэмшүүлэх тохиолдолд тус компанийн 26.9 хувийг Монгол Улсын иргэд эзэмшихээр байгаа бөгөөд цаашид энэ хувиар нэмэгдүүлснээр хувьцааны хувь хэмжээ улам бүүр нэмэгдэх тооцоо гарч байгаа талаар төслийн үзэл баримтлалд дурдсан байна. Өөрөөр хэлбэл 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн болон харьяат болсон, 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд оногдох хувьцааны тоог тусгайлан заагаагүй боловч нийт хувьцааны 34 хувь багтаан эзэмшүүлэх гэсэн ерөнхий агуулгыг тусгасан нь ирээдүйд иргэнд ноогдох хувьцааны тооны хэмжээ нэрлэсэн хувьцааны үнэд өөрчлөлт орох тэгш бус байдлыг бий болгох эрсдэлийг дагуулж байна.

Нөгөө талаар Монгол Улсын иргэн бүр адил тэнцүү хэмжээгээр Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 1072 хувьцааг эзэмших эрхтэй гэж үзвэл өсөн нэмэгдэх хүн амын тоо болон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нийт хувьцааны 34 хувийн хоорондох хамаарал тооцоо судалгаа байхгүй байгаа тул төслийн хэрэгжих боломжийн талаар дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

Төслийн үзэл баримтлалд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт түүнд тусгагдсан газрын хэвлийн баялгийн үр өгөөжийн дийлэнх нь ард

түмэнд ноогдож байх үзэл санааг хэрэгжүүлэх хүрээнд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нийт хувьцааны 34 хувийг Монгол Улсын иргэн бүрд адил тэнцүү хэмжээгээр үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх түүнтэй холбогдсон зохицуулалтыг нэг мөр цэгцлэн хэрэгжүүлэх зорилгоор тогтоолын төслийг боловсруулсан гэжээ. Гэтэл Үндсэн хуулийн уг үзэл санааг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын нийт иргэд, ирээдүйд төрөх хүүхдүүд, Монгол Улсын харьяат улсын иргэдэд цаашид тодорхойгүй хугацаагаар хувьцаа хэлбэрээр эзэмшүүлж ноогдол ашиг хуваарилах байдлаар хэрэгжүүлэхээр тогтоолын төсөл боловсруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалтай зөрчилд зөрчилдөж байна. Үндэсний баялгийн хуваарилалтын зарчмыг ТӨК-ийн хувьцааг эзэмшүүлж ноогдол ашиг хуваарилах байдлаар шийдэх нь уг харилцааг бүхэлдээ Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын тухай хуулийн үйлчлэлд хамааруулах цаашилбал төрийн өмчийг хувьчлах агуулга руу оруулах эрсдэлийг дагуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолоор Байгалийн баялгийн зохицуулалтын талаарх нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэлийг баримтлахаар заасан боловч Засгийн газраас одоо хүртэл төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхгүйгээр иргэдэд хувьцаа байдлаар ноогдол ашиг хуваарилах асуудлыг Улсын Их Хурлын тогтоолын хэлбэрээр шийдвэрлэж байгаа нь Үндсэн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдөж байна. Үүнд байгалийн баялаг ард түмний мэдэлд төрийн нийтийн өмч байх эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ энэхүү баялгийг төр өмчлөх, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашигласны

үр өгөөж, татвар, ашиг гэх мэтийн дийлэнх нь буюу 50-аас дээш хувь нь Монголын ард түмэнд ноогдох шаардлагатай бол иргэдийн саналыг харгалзан Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх зарчмыг хуульчлах.

2. Үндэсний баялгийн сан нь хөгжлийн болон хуримтлалын сан байх бөгөөд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын нөөц ашигласны төлбөр төрийн өмчийн хувьцаа борлуулсны орлого, газрын тос, байгалийн хийн бүтээгдэхүүн хуваах гэрээний орлого, төрийн өмчийн хувьцааны ноогдол ашиг Сангийн хөрөнгө оруулалтын цэвэр ашгийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх.

3. Сангийн хөрөнгийн удирдлагын компани уг сангийн хөрөнгийн удирдлагыг хараат бусаар бие даан хэрэгжүүлэх, компанийн болон сангийн удирдлагын сайн засаглалыг хэвшүүлэх, сангийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг зохистой хэлбэрээр хэрэгжүүлэх бөгөөд сангийн хөрөнгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэддээ хүртээхдээ тэгш байдал шударга ёсны зарчмыг дээдлэх, сангийн хөрөнгийн удирдлагын компанийн давуу эрхийн хувьцааны ноогдол ашиг олгох.

4. Газрын хэвлийн баялаг ашигласны улмаас хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг хангах байгалийн тэнцлийг хадгалах зэрэг болно.

Компанийн тухай хуулийн 32.1-д Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу компанийн хувьцаа нь компанид хөрөнгө оруулж түүнийг үндэслэн санал өгөх, ноогдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрхийг гэрчилнэ гэж заасан. Өөрөөр хэлбэл хувьцаа гэдэг бол хөрөнгө эзэмших эрхийн баталгаа бөгөөд тухайн компанийн өмчийн тодорхой хувийг

эзэмшиж буйг илэрхийлсэн баримт бичиг болохын хувьд эдийн засгийн эрх буюу ноогдол ашиг авах, үлдэгдэл хөрөнгөөс хувь хүртэх эрх, компаниас өөрийн хувьцааг шударга үнээр худалдаж авахыг шаардах эрх, удирдлагын эрх буюу ХЭХ-д саналын эрхтэй оролцох, санал оруулахыг шаардах эрх, мэдээллийн эрх зэргийг хэрэгжүүлдэг.

Цаашид иргэд эзэмшүүлэх хувьцааны тоо хэмжээ, нэрлэсэн үнийн талаарх зохицуулалтыг Компанийн тухай хуулийн 32.4-д хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байх бөгөөд тухайн компанийн нэг төрлийн хувьцааны нэрлэсэн үнэ ижил байна.

Мөн хуулийн 32.5-д хувьцааг нэрлэсэн үнээс нь доогуур үнээр гаргахыг хориглоно гэж заасантай зөрчилдөхөд хүрээд байна. Түүнчлэн төслийн үзэл баримтлалд 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэдэд хэрхэн хувьцаа эзэмшүүлэх асуудлыг нэр мөр зохицуулах шаардлага үүссэн талаар дурдсан боловч тогтоолын төсөлд нийт хувьцааны 34 хувьд багтаан эзэмшүүлэх гэснээс өөрөөр нарийвчилсан зохицуулалт хугацааны талаар тусгаагүй байна.

Хэдийгээр төслийн 1 дэх заалтын 4-д иргэн бүр хувьцаа эзэмших эрхийг 2028 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл олгохоор зохицуулалтыг тусгасан боловч энэ зохицуулалт нь зөвхөн тухайн заалт буюу компанийн хувьцааны 1072 хувьцааг эзэмшиж байгаад зарим хэсгийг эсхүл бүхэлд нь худалдсан, суутган тооцуулсан Монгол Улсын иргэд хүсэлт гаргасан тохиолдолд нэрлэсэн үнээр нь буцаан авч хувьцаа эзэмших эрхийг олгоход хамааралтай гэж ойлгогдохоор байгааг анхаарах шаардлагатай байна.

Төслийн 1 дэх заалтын 3-д иргэн нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бүртгэлээс хасагдаж байхаар энэ

тогтоолд заасан хувь хэмжээнд багтаан зохион байгуулахаар тусгажээ. Иргэний хуулийн 101 дүгээр зүйлд заасны дагуу өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр хуулиар тогтоосон хэмжээ хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй гэж заасан нь өмчлөх эрхийн мөн чанар болдог. Компанийн тухай хуулийн 45.1-д зааснаар компани нь үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх үүрэг хүлээдэг. Компанийн тухай хуулийн 49.1-д компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь ТУЗ-ийн шийдвэрээр өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно гэж заасан. Өөрөөр хэлбэл нэгэнт компанийн хувьцаа эзэмшигч болохын хувьд иргэдийн хувьцааг эргүүлэн худалдан авах харилцааг компанийн дүрэмд тусгайлан заагаагүй бол хуулиар зохицуулахаар тусгасан байна.

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн дүрмээр уг харилцааг тусгайлан зохицуулаагүй байна. Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаанаасаа татгалзах эсэх асуудлыг өөрөө шийдэх бүрэн эрхтэй. Иргэний хуулийн 515.1-д заасны дагуу өмчлүүлэгчийн эд хөрөнгө эрх өвлөгдөхөөр заасан атал төсөлд хувьцаа эзэмшигчийн бүртгэлээс хасагдаж байхаар тусгажээ.

Компани нь давуу эрхийн болон энгийн хувьцаа гаргах, хувьцаагаа эргүүлэн авах зэрэг асуудлыг Компанийн тухай хуулийн 33.3, 42.1, 62.1.12, 76.1.7-д заасны дагуу компанийн дүрмээр эсхүл Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ нь шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл өмчлөгч өмчлөлийн зүйлсээ хэрхэхээ өөрөө шийдэх бөгөөд энэ эрхийг Иргэний хуулийн 103.1 дэх хэсэгт заасны дагуу зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлах боломжтой. Хувьцаат компанийн хувьд эзэмшигчийн хувьцаагаа захиран

зарцуулах эрх, хувьцаа шилжих чөлөөт байдал гэсэн үндсэн зарчмуудыг Компанийн тухай хуулиар баталгаажуулсан. Харин тусгай хуульд өөрөөр заах замаар хувьцаа эзэмшигчийн хувьцаагаа захиран зарцуулах эрхийг хязгаарлах боломж нээлттэй юм. Ийнхүү төсөлд өмчлөгчийн талаар хамгаалагдсан эрхэд халдсан агуулгыг тусгасан нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байна.

2. Хэлбэрийн болон хууль зүйн техникийн шаардлага хангасан эсэх. Төсөл Улсын Их Хурлын тогтоол хэлбэртэй байгаа нь Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа түүний үр өгөөжийн дийлэнх ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтоохоор, 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болохоор заасантай тус тус нийцэхгүй байх бөгөөд хэрэв энэ шийдвэрийг Улсын Их Хурлаас гаргах шаардлагатай гэж үзвэл хуулийн хэлбэртэйгээр гаргах нь зүйтэй байна.

Дүгнэлт.

1. Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслөөр Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны 34 хувийг Монгол Улсын иргэн бүрд адил тэнцүү хэмжээгээр үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх, байгалийн баялгийн үр өгөөжөөс иргэн бүрд тэгш хүртээх боломжийг олгох эрх зүйн орчныг бүрдүүлэхээр зохицуулсан нь Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш шударга хүртээхэд чиглэнэ.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж заасантай. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолтой тус тус зөрчилдөж байна.

Хоёр.Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 3 дахь дэд заалтын иргэн нас барсан, Монгол Улсын харьяатаас гарсан тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бүртгэлээс хасагдаж байхаар энэ тогтоолд заасан хувь хэмжээнд багтаан зохион байгуулах гэсэн нь Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт төр нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.

Мөн зүйлийн 3 дахь хэсэгт өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно гэж, 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хөдлөх үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах дайчлан авахыг хориглоно. Төр түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор үнийг төлнө. 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад тухай баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж, Иргэний хуулийн 103.1-д өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлана гэж заасантай нийцэхгүй байна. Эрх зүйн дүгнэлтийг танилцуулж дууслаа.

Ц.Цэрэнпунцаг: Мягмар даргад баярлалаа. Ингээд ажлын хэсэг

танилцуулъя. Ш.Мөнхцэрэн ЗГХЭГ-ын салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Ч.Дондогмаа ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга, Ч.Нямдэлгэр ЗГХЭГ-ын салбарын бодлого зохицуулалтын газрын Засгийн газрын референт, Ч.Төгөлдөр УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга, Ч.Мөнх-Оргил СЗХ-ны Хуулийн хэлтсийн дарга, С.Наранцогт Эрдэнэс Монгол ХК-ийн гүйцэтгэх захирал.

Ажлын хэсгийн танилцуулга болон эрх зүйн дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү.

Ундрам гишүүнээр тасаллаа. Ингээд Батлут гишүүнийг оруулаарай. Батлут гишүүнээр тасаллаа. Ингээд Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Сая би Эдийн засгийн хөгжлийн сайдтай ярьж байхад бас нэг таатай мэдээ ярьж байна л даа. Нүүрсний биржээр орж ирж байгаа бол ер нь нүүрсний экспортоос 2 тэрбум ам.долларын ашгийг бид энэ бирж ажиллуулснаас хойш олчихоод байгаа гээд. Өнөөдөр манай улсын валютын нөөц бол 5 их наяд ингээд давчхаад байгаа. Өөрөөр хэлбэл нүүрсний экспортын энэ Эрдэнэс Тавантолгойг бас ил тод, нээлттэй, бас хариуцлагатай, хяналттай болгосноор яаж өгөөж нь илүү ингэж гарч байгааг бид харж байна. Харин өнөөдөр үүнийгээ бид аль дээр үеэс хойш яриад байгаа. Үндэсний баялгийн сандаа хэдийнээ хийчхээд нөгөө энэ мөнгө маань тэгээд одоо болоод ирээдүйн хүн бүрд тэгш хүртээх гээд энэ Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгтэйгээ нийцээд явж байх боломж байсан нь одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулаад.

Ингээд Үндэсний баялгийн сан байна гэсэн. Өнөөдөр нөгөө эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх жишээлбэл нийслэл Улаанбаатар хотод бараг 99

хувь зөрчигдөөд явж байгаа. Би үүнийг анх гишүүн болсон өдрөөсөө л хойш энэ агаар хөрсний бохирдлыг буулгая. Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд сервис центр дэд төв гэж байгуулж болдог юм байна гээд өнөөдөр гэхэд 3400-гаад айл өрхийг яндан нүхэн жорлонгоос салгасан. Гэхдээ ганц хүн хийдэггүй. Үүнийг бүүр бодлогоор ингэж хийгээд дэд бүтцийг татаад энэ нь өөрөө нөгөө баялгийн сангийн мөнгө улс орны хөгжлийн урт хугацааны бодлоготой нийцээд тэгээд иргэнийхээ нөгөө аюулгүй эрүүл орчинд амьдрах энэ эрхээ эдлээд явж байх бололцоог бүрдүүлэх ёстой байтал ингэж чадаагүй. Тэгэхээр одоогийн бид нарын оруулж ирж байгаа тогтоолоор би бас ажлын хэсэгт орсон. Энэ 2012 оны 4 сарын 12-ноос 2022 оны 12 сарын 31-ний хооронд төрсөн 944.8 мянган хүүхдэд хувьцааны ноогдол ашгийг олгох тухай асуудал орж иржээ. Үүнийг дэмжиж байгаа. Энэ бол зайлиггүй бай байх ёстой зүйл.

Харин одоо Наранцогт даргаас би асуугаад байгаа. Нэгэнт л үнэ ханин инфляцтайгаа уяад бодоход энэ Эрдэнэс Тавантолгой компанийнхаа 2021, 2022 оны ноогдол ашгийг иргэддээ ямар нэг байдлаар, ямар нэг хэлбэрээр хүртээх асуудлыг бид бол цаг алдалгүй хийх ёстой. Үүнийг би аль эртнээс яриад байгаа. Бид өмнө нь 2021, 2022 онд бололцоо байхгүй байсан гэсэн түүнийг ч харсан. Нэг хэсэг нь хулгайн замаар нүүрс маань алга болчихсон нөгөө хэсэг нь өр төлбөрүүдийн хооронд явчихсан. Үүний хохирогч нь жирийн хувьцаа эзэмшигч иргэд болоод байгаа. Тийм учраас бид иргэдээ хохироож болохгүй энэ ноогдол ашгийг ямар нэг хэлбэрээр бол олгох ёстой. Би үүнийг цагаан сараас өмнө олгож өгөөч гэж ТУЗ-ийн дарга Наранцогтод хэлж байсан.

Аудитын дүгнэлтийг бас хийлгэж байгаа гэж байна. Тэгэхээр энэ дээр би хариулт авахыг хүсэж байна. Энэ ноогдол ашиг хуваарилахаас гадна энэ

хүүхдүүд маань бүүр ороод тэгээд 2021, 2022 оны ноогдол ашгийг иргэддээ ямар нэг хэлбэрээр хүртээмжтэй хүртээх асуудлын тооцоо судалгаануудыг яаж хийж байгаа вэ. Үүнийгээ Үндэсний баялгийн сангийнхаа хуультай уялдаад зохион байгуулчих бололцоо байгааг бид нар бас эндээс харж байна.

Үүнээс гадна Энхбаяр даргаар ахлуулсан манай Нүүрсний сонсголын түр хорооны дүгнэлт дээр ч гэсэн ТӨК-ууд ялангуяа энэ Эрдэнэс Тавантолгой шиг компаниудын хариуцлагатай болгох бас энэнтэй холбоотойгоор ноогдол ашгийг иргэддээ хүртээх асуудлыг судалж, үүнийг цаг хугацаандаа хийх ийм чиглэлүүдийг бас өгсөн байгаа. Тэгэхээр энэ чиглэлүүдээр онцгой анхаараад цаг хугацаа алдалгүй бид бас асуудлыг шийдэх хэрэгтэй байгаа. Үүнийг 2020 оноос хойш ярьж байгаа. Гэхдээ та нар маань тооцоо судалгаа хийгээд өгөх тал дээр анхаарч ажиллаж байгаа талаар Засгийн газрын зүгээс мэдээлж байсан.

Ингээд ямар ч байсан нүүрснийхээ энэ экспортыг хяналтдаа аваад, ил тод болгоод өнөөдөр ингээд 2 тэрбум ам.долларын ашгийг жилийн дотор бараг ингээд олж байна шүү дээ. Уул уурхайн биржийн тухайд ярихад. Тэгэхээр энэ ноогдол ашгийг хүртээх асуудлыг анхаарч шийдэж өгөхийг хүсэж байна. Энэ дээр хариулт авъя.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 4 номер ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн хариулъя. Дараа нь ажлын хэсгээс хариулаарай.

Б.Баттөмөр: Сая Засгийн газраас оруулж ирсэн саналтай холбогдуулаад хууль зүйн дүгнэлт гаргуулахаар бид нар ажиллаад, сая Мягмар дарга хууль зүйн дүгнэлтийг уншаад танилцуулчихлаа. Засгийн газрын оруулж ирсэн энэ тогтоолын төсөл бол Үндсэн хуулийн энэ холбогдох заалтуудыг зөрчиж байна гэсэн дүгнэлтийг

гаргачихсан байгаа. Тэгэхээр бид нар энэ дээр ажиллаад үндсэндээ 2012 оны 4 сарын 1-нээс хойш 2023 оны 12 сарын 31-нийг хүртэл 1 сая 5 мянган хүүхэд байгаа юм. Энэ хүүхдүүддээ энэ хувьцааг нь өгье гэснээ, Монгол Улсын харьяатад орсон бас хэдэн хүн байгаа юм. Ингээд үүний хувьцааг нь олгоё, ингэснээрээ бол тэгш байдал хангагдана. 2.5 сая хүн нь хувьцаатай, 1 сая хүн нь хувьцаагүй байгаад байж болохгүй. Тэгээд үүнийг ингэж өөрчилж оруулж ирж байгаа 1 дэх асуудал.

2 дахь асуудал бол энэ урд талд нь өгсөн хувьцаанууд, одоо өгөх хувьцаанууд бол ямар ч бүртгэлгүй байгаа. Тийм учраас Эрдэнэс Тавантолгой нь энгийн хувьцаагаар бүртгэж авъя гэсэн ийм заалтууд энд ингээд ороод явж байгаа юм. Сая Оюунчимэг гишүүний тэр ногдол ашиг хуваах ёстой, би бас адилхан саналтай байгаа. 2021, 2022, 2023 оны үндсэн үйл ажиллагаанаас олсон ашгаас энэ хувьцаа эзэмшигчид өгөх ёстой. Үүнийг юу вэ гэхээр, тэр Үндсэн хуулийн заалт байгаа шүү дээ. Тэр баялгийн сангаараа дамжуулж ард иргэддээ олгоно гэж. Баялгийн сангийн хууль бол өргөн баригдаж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Баялгийн сангийн хууль дээрээ энэ асуудлуудыг ноогдол ашгийг ойрын хугацаанд олгох ийм боломжтой нөхцөл байдал бүрдсэн гэж ойлгож байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс гүйцээж хариулах уу. Болж байна уу. Ажлын хэсгээс 4 номерын микрофон.

С.Наранцогт: -Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Ноогдол ашиг хуваарилах тухай асуудал бол компанийн тухай хууль дээр нэлээн их тодорхой заачихсан 3 нөхцөл байгаа, 47 дугаар зүйлээр зохицуулагдсан байгаа. Компанийн тухай хууль дээр мөн санхүүгийн жилд дууссанаас 50 хоногийн дотор ТУЗ хуралдаж, Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан энэ нөхцөл хангагдсан тохиолдолд бол

ноогдол ашиг хуваарилах ийм шийдвэрийг гаргана. Яг энэ хуулийнхаа дагуу энд холбогдох шийдвэр гарна гэж ингэж үзэж байгаа. Тэгэхээр энэ Эрдэнэс Тавантолгой компанийн хувьд бол энэ удахгүй ТУЗ энэ хуулийн хугацаанд хуралдаж санхүүгийн тайлан аудитаар батлагдсаны дараа шийдвэр гарна. Мэдээж хэрэг 2023 оны хувьд компани сайн ажилласан. Ашгийн хувьд нэлээн гайгүй ашигтай гарна.

Гэхдээ нөгөө талдаа хуримтлагдсан өр төлбөр нэлээн өндөр байгаа. Тэгэхээр ноогдол ашгийг хуваарилсны дараа энэ хөрөнгийн хэмжээ ямар харьцаатай байхыг ингээд хуульчилчихсан байгаа учраас энэ ирэх оныхоо үйл ажиллагааны мөнгөн хөрөнгийн урсгалын төлөвлөгөөтэй ингээд уялдуулаад ТУЗ бол шийдвэр гаргана бодож байгаа. Өнөөдөр ч гэсэн ноогдол ашиг олгох тухай өнөөдөр хэлэлцэж байгаа асуудлыг энэ хувьцаагүй хүмүүст хувьцааг нь өгөх тухай асуудлаар жагсаал цуглаан бас компани дээр болоод байгаа юм байна билээ. Нэгдүгээрт ийм байна.

Хоёрт, Та нөхөж олгох тухай асуудлыг ярьж байгаа. Давуу эрхийн хувьцааг бол нөхөж олгодог. Тэгэхээр энэ хувьцаан дээр 2010 оны 39 дүгээр тогтоол дээр бол хувьцааг нь эзэмшүүлнэ гэхээд, компанийн баланс дээр бол энгийн хувьцаагаар бүртгэлтэй тэгээд яг ингэж ямар хувьцаа вэ гэдгийг нь албажуулсан зүйл байдаггүй юм. Өөрөөр хэлбэл, энэ иргэдэд олгосон хувьцаа бол ямар төрлийн хувьцаа вэ. Ер нь энэ 1072 гээд ерөнхий ойлголтоороо компанийн баланс дээр энгийн хувьцаа гэгчихсэн.

Тэгээд үүнээсээ болоод энэ хувьцааны төрөл нь тодорхой биш учраас ажлын хэсэг дээр бид нар нэлээн ярьж байгаад энэ хувьцааг одоо олгохдоо шууд энгийн хувьцаагаар олгоод өмнө нь олгосон үнэ төлбөргүйгээ энгийн хувьцаагаар бүртгэ гэдэг ийм заалтыг

бүүр тодруулж өгч байгаа юм. Тэгэхээр энэ яг хувьцааныхаа энгийн хувьцааны эрх мэдэл нь иргэдэд бий болно гэсэн үг. Давуу эрхийн хувьцаа биш учраас үүний ноогдол ашгийг нөхөж олгоно гэдэг асуудал бол хүндрэлтэй. Давуу эрхийн хувьцаан дээр олгоогүй бол нөхөж олгож болдог ийм л хуулийн зохицуулалт байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг нээе.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ Эрдэнэс Тавантолгой компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай гээд тогтоол орж ирсэн. Би энэ тогтоолыг олж ирээд бас аятайхан зөв тогтоол ороод ирлээ гээд баярласан л даа. Гэтэл бас л дутуу ороод ирлээ. Баттөмөр гишүүн та өөрөө мэдэж байгаа 2022 оны 12 сарын 23 одоо жил гаруйн өмнө Уул уурхайн биржийн хууль та бид ажлын хэсэгт нь орж байгаад батлуулаад ингээд гаргасан.

Энэ тогтоолын хавсралтаар Улсын Их Хурлын 2 дахь тогтоолыг нь баталж бид нар гаргасан. Энэ тогтоолоор юу гэсэн гэхээр Эрдэнэс Тавантолгой компанийн хувьцааг нэгдүгээрт эргэлтэд оруулъя. Хоёрдугаарт, ноогдол ашгийг олгоё гэсэн шүү дээ. Тэгээд өнөөдрийн энэ тогтоолоор ноогдол ашиг орж ирж байгаа юм байх гээд тэгсэн чинь ноогдол ашгаа хаячхаад л гараад ирж байна шүү дээ.

Сая нүүрсний холбоотой асуудлууд нэлээн өндөр түвшинд явагдсан. Бүтэн 7 хоног бид нар хуралдаад ярьсан. Эрдэнэс Тавантолгой компанийн дотоод асуудлууд, тэр тендерийн асуудлууд, тэр гүйцэтгэлтэй холбоотой асуудлууд, тэр гүйцэтгэх компаниудын асуудал гээд энд чинь 5.2 байсан байх. Сая тонн нүүрсний асуудал хүртэл ингээд тусгаад, хаа сайгүй шат, шатдаа хулгайн асуудал чинь гараад ирсэн шүү дээ. Тэгээд үүний ар дээр юу

хийх вэ гэхээр, тэр хүмүүс ямар хэмжээнд хуулийн хариуцлага хүлээх юм гэдэг нэгдүгээр асуудал байж байгаа.

Хоёрдугаарт, компани чинь үнэхээр сүүлийн үед БЭТ томилоод бүрэн тогтоочих хэмжээндээ орчихсон юм бол одоо ноогдол ашгаа өгөх хэрэгтэй байна шүү дээ. Тэгэхээр шууд би энэ тогтоол дээр дахиад нэмэлтийг нь оруулж ирээд яагаад болоогүй юм бэ? Шууд ард иргэддээ ноогдол ашиг олгуулъя гэсэн ийм тогтоолын үг, үсэгтэй зүйл энэ тогтоолд орж ирэх хэрэгтэй л гэж бодоод байгаа юм.

2022 оны Улсын Их Хурлын тогтоол дээр ноогдол ашгийг олгуул гээд Засгийн газарт Улсын Их Хурал даалгавар өгчихсөн, үүрэг өгчихсөн. Одоо хэрэгжүүлэх хэрэгтэй байна шүү дээ. Одоо ноогдол ашгаа өгөх хэрэгтэй. Сая ерөнхийдөө 3 их наяд төгрөгийн ашигтай ажиллалаа гэж байсан. Энэ Уул уурхайн биржийн тухай хууль гарч ирснээр ил тод зардаг болж, 100 доллароор зардаг байсан нүүрс маань 180 доллароор зарагдсан. Нийт улсын төсөв 1.8 их наяд төгрөгөөр биелсэн. Улсын 2023 оны төгсгөлийн баланс аар энэ чинь бараг 2 их наяд гараад явчихсан байх ёстой шүү дээ. Ийм хэмжээний мөнгө олоод, ийм хэмжээний бид нар орлого олж байгаа өнөөдөр ард иргэддээ өгөх цаг нь болчихоод байна. Ноогдол ашгаа өгөх цаг нь болчихоод байна. Тэгээд энэ дээр ийм заалт яагаад оруулж ирж болохгүй байсан юм бэ? Оруулж ирж болж байна уу, үгүй юу.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгээс, ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн хариулна. Ингээд дээрээс нь товчхон бас Ж.Бат-Эрдэнэ гишүүний саяын асуулттай холбоотой яагаад бид нар энэ ажлын хэсэг дээр энэ асуудлыг таны асууж байгаа энэ ноогдол ашиг хуваарилах асуудлыг авч хэлэлцээгүй вэ, энэ тогтоол зохицуулахгүй байгаа юм бэ гэхээр энэ бол нэгдүгээрт, Засгийн газраас өргөн мэдүүлсэн тогтоолын

төслийн үзэл баримтлалд энэ тусгагдаагүй. Зөвхөн 2012 оны 4 сар 11-нээс хойш төрсөн хүүхдүүдэд энэ компанийн энгийн хувьцааг эзэмшүүлэх асуудлыг өргөн мэдүүлсэн учраас бол энэ асуудал бас ажлын хэсэг дээр яригдаагүй байх. Ингээд Баттөмөр гишүүн хариулъя. Энэ ажлын хэсгийн ахлагч Баттөмөр гишүүн хариулъя.

Б.Баттөмөр: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Бат-Эрдэнэ гишүүн сая тэр бол Уул уурхайн биржийн тухай хуулийн талаар ярилаа. Бид нар хамтарч ажиллаж энэ Уул уурхайн биржийн хуулийг батлуулсан. Монголын эдийн засагт бол энэ 4 жилд маш том гэрэл гэгээ авчирсан шүү энэ бол. Далд эдийн засгийг ил болгосон, хулгайг байхгүй таслан зогсоосон. Дээрээс нь Монгол Улсын энэ бүх санхүүгийн данс ашигтай гарч байгаа. Тэгээд дээрээс нь өнгөрсөн 30 жилийн хугацаанд ганц удаа л үндсэндээ төлбөрийн тэнцэл гэдэг үзүүлэлт бол ашигтай. Бусад нь бол 30 жил шахуу алдагдалтай. 30.4 тэрбум долларын алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл, энэ жил 1 тэрбум орчим долларын ашигтай гарч байна шүү дээ. Энд энэ уул уурхайн биржийн оруулсан хувь нэмэр бол үнэхээр их ач холбогдолтой байсан. Үүнийг би бас хэлэхийг хүсэж байна. Сая Цэрэнпунцаг дарга хэлчихлээ. Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ хуулийн үзэл баримтлалд ноогдол ашгийг тараа гэсэн юм бол байхгүй байгаа юм. Ноогдол ашгийг өгье гэсэн.

Тэр 34 хувийг нь эзэмшүүлье гэсэн ийм юм орж ирсэн юм байгаа. Сая Мягмар даргын танилцуулсан энэ хууль зүйн дүгнэлтэд ч гэсэн тэгж байна шүү дээ. Стратегийн ач холбогдол бүхий ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн үр өгөөжийн дийлэнхийг нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гээд заачихсан байгаа юм. Тэгээд энэ тогтоолоор тэр ноогдол ашгийн асуудлыг хөндөж болохгүй

байгаа юм. Энэ хүүхдүүдэд 1 сая 5 мянган хүүхдэд үүнийг өгнө гэдэг маань юу вэ гэхээр өөрөөр хэлбэл ноогдол ашгийг өгөх нэг алхам хийж байгаа юм.

Түүрүүн би бас хэлсэн. Баялгийн сангийн тухай хууль өргөн баригдаж байна. Энэ хуулиар ноогдол ашгийг өгөх эрх зүйн үндэс нь ингээд бүрдэх юм. Тун ойрын хугацаанд энэ хийгдэнэ гэж би найдаж байгаа. Яг энэ тогтоолд тэдэн төгрөг эдэн төгрөг гэж тоо тусгах боломжгүй. 2023 оны баланс гараагүй байна. Урьдчилсан тооцоогоор бол нэлээн сайн ашигтай ажиллачихсан байгаа. Ер нь боломжийн үр өгөөжийг тараачих, хувьцааны өгөөжийг тараачих ийм боломж бүрдчихсэн байгаа гэдгийг хэлье. Хуулиар зохицуулъя.

Ц.Цэрэнпунцаг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Ёндон сайд байхдаа өргөн барьсан Уул уурхайн биржийн тухай хууль та бид бас ажлын хэсгийг нь ахлаад ингээд батлуулсан. Энэ хуулийг дагалдуулаад Улсын Их Хурлын тогтоол явсан. Тогтоол дээр 1072 хувьцааг эргэлтэд оруул, дээрээс нь ноогдол ашиг олгох гэсэн ийм заалт үг, үсгээрээ байгаа юм. Энэ талаар судалж буцаж Улсын Их Хуралд танилцуул гэсэн. Тэгээд би буцаад орж ирж байгаа нь тогтоолд нь ийм юм орж ирэх байх гэсэн чинь өөр юм ороод ирж байгаа юм. Тэгээд үүнийг хэлээд байгаа юм. Бага, багаар ингээд, ингээд л дөхөөд яваад байдаг.

Тэр 2022 онд батлагдсан тогтоолын ар дээр цагаан сараар ард иргэд ерөөсөө энэ ноогдол ашиг олох юм байна гэсэн нэлээн тийм горьдлого үүссэн шүү дээ. Одоо дахиад энэ орж ирэнгүүт нь дахиад нэг горьдлого үүсгэчихэж байгаа юм. Цагаан сараас өмнө ч юм уу гаргах юм байна, ноогдол ашиг олох юм байна гэсэн нэг ийм горьдлого тээчихдэг. Гэтэл бид нар дахиад л хариулж байгаа, явж байгаа юм

маань дахиад нэг, нэг алхмаар урагшаа л явчхаад байгаа байхгүй юу даа.

Ц.Цэрэнпунцаг: Бат-Эрдэнэ гишүүн ерөнхийдөө санал хэллээ. Баттөмөр гишүүн нэмж хариульъя.

Б.Бат-Эрдэнэ: Энэ Улсын Их Хурлын тогтоолоор ноогдол ашиг тарааж болохгүй байгаа юм. Үндсэн хуулийн энэ холбогдох заалтыг 1 дүгээрт зөрчиж байгаа. Хоёрдугаарт, одоо яг ноогдол ашиг тараана гэхээр зэрэг тэр 2 сая 500 мянган хүнд тараана. Нөгөө шинэ төрсөн хүүхдүүд байхгүй. Хувьцаа эзэмшээгүй байгаа юм чинь.

Тийм учраас сая хүүхдүүдэд 2012 оноос хойш төрсөн хүүхдүүдэд ингээж эзэмшүүлснээр Монголын 3.5 сая хүн ноогдол ашиг авах ийм боломж бүрдэж байгаа юм. Үүнийг тэр ноогдол ашгийг цагаан сараас өмнө авах барих энэ асуудлыг би эд нараас шалтгаална. Бид үүнийг тэр баялгийн сангийнхаа хуулийг яаралтай өргөн баригдсан хуулиуд байж байгаа. Энэ дээрээ ажиллаад эхлэх юм бол тэгээд үүнийг цагаан сараас өмнө тараах боломж бол байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Нэмээд хариулчихад өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хүрээнд энэ компанийн ТУЗ ямар хэмжээтэй ашгаа дивиденд хэлбэрээр тараах юм гэдэг шийдвэр гаргах бүрэн эрх нь байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг хамгийн гол нь өнөөдрийн энэ Их Хурлын тогтоол бол тэр бид нар хоцорчлоод байгаа. Өнөөдөр компани дивидендээ хуваариллаа, ашгаа хуваариллаа гэхэд сая 200 мянган хүүхэд хоцорчих гээд байгаа учраас тэрний асуудлыг шийдье гэж оруулж ирж байгаа болохоор бас том асуудал шийдэж байгаа. Түрүүн ч хэлсэн. Өнөөдөр ингээд шууд тараачихна гэвэл компани өнөөдөр ТУЗ-ийн шийдвэр гарлаа, ашиг нь байна, тараачихъя гэхээр 2 сая 500 мянган хүнд тараана. Бид нар энэ тогтоолоо гаргаад тараах юм бол 3 сая 600-д тараах нь.

Тэгэхээр цагаан сарын өмнө ард түмний гар дээр очих бэлэн мөнгөний хэмжээ нь ихэснэ гэсэн үг. Ингээд Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Сайн байцаана уу. Надад 3 асуулт байна. Нэгдүгээрт, нийт ноогдол ашгийн зориулалтаар хэдий хэр хэмжээний мөнгийг төсөвлөж байгаа вэ. Төрийн өмч нь 81 хувьтай, 19 хувь нь иргэдийн гар дээр байгаа хувьцаа. Тэр иргэдэд өгөх мөнгө нь нэг хүнд ойролцоогоор 500 мянган төгрөг гэж ойлгогдож байгаа юм байна. Тэгэхээр нийтдээ хэдэн төгрөгийн ноогдол ашиг байдлаар хуваарилахаар юм тооцож байгаа юм нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт, энэ 1.3 дахь заалтаар энэ ЭТТ компанийн төрийн өмчит оногдох тэр ноогдол ашгийг нь охин компани болон бусад компаниудын өр авлагад зарцуулна суутган тооцно гэхчхэн байна. Тэгэхээр энэ ямар хэмжээний өр авлагын асуудал яригдаж байгаа юм. Тэгээд энд болохоор иргэдэд өгөх ноогдол ашгийнхаа асуудал нь хаягдаад, зөвхөн хувьцааг нь бүртгээд, тэгэнгүүт төрд оногдох ноогдол ашиг нь болохоор ингээд шууд авна. Компани хоорондын тооцоо авлагынх нь асуудлыг цэгцэлнэ гээд ороод ирчихсэн байна.

Тэгэхээр ямар хэмжээтэй ямар асуудал, ямар, ямар өр авлага байдаг юм. Энэ талаар нэг мэдээлэл авмаар байна. Аль эсвэл үүнийг хэрвээ тэр Баялгийн сангийн хууль орж ирээд батлагдах гэж байгаа юм бол тэр Баялгийн сангийн хуулиа дагуулаад үүнийгээ хийж болоогүй юм уу гэдэг асуулт байна.

Гуравдугаар асуудал, сая энэ нүүрсний сонсгол дээрээс би ганц л юмын нэг ойлгосонгүй л дээ. Энэ төмөр замыг бол анхны 2009 онд гарсан ТЭЗҮ-гээр 750 сая доллароор төмөр замыг нь, холбох цэгийг нь, хөдлөх бүрэлдэхүүнтэй нь, зөрлөгтэй нь ингээд хийнэ гэсэн төсөв гарсан байна. Тэгээд бид нар яг тэр Гацуунсүхайтын чиглэлийн төмөр

замыг хөдлөх бүрэлдэхүүнтэй нь, зөрлөгтэй нь, холбох цэгтэй нь яг хэдээр ер нь засаг яг барьж байгаа вэ. Энэ 3 асуулт дээр хариу авчихмаар байна.

Ц.Цэрэнпунцаг: Ганхуяг гишүүн 3 асуулт хариуллаа. Тавантолгойгоос Наранцогт захирал байгаа.

2 дахь асуулттай холбоотой асуултад тодруулаад Ганхуяг гишүүнд 2 дахь асуулттай холбоотой ажлын хэсгээс гаргасан саналууд байгаа юм шүү. Гаргаж ирсэн учраас бид нар энэ гишүүд энэ дээр сайн ярилцаж бас саналаа хураах ёстой. Ингээд асуултад 4 номер хариулъя. Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээе.

С.Наранцогт: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Ноогдол ашигийн хэмжээ гэж. Тэгэхээр компанийн 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан эцэслээгүй байна. Эцэслээгүй байгаа учраас бид яг нэг ноогдол ашигт өдийг, төдийг хуваарилна гэдэг тоо гараагүй байна. Хоёрт, би түрүүн бас асуултад хариулахдаа хэлсэн. Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд бол компанийн ноогдол ашигийг хуваарилах энэ нөхцөлд заасан хамгийн гол заалт бол ийм заалт байгаа. 47.1.1-д ноогдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх гэсэн ийм заалт. Тэгэхээр таны 2 дахь асуудалтай бас уялдана. Өнөөдөр компани бол хуримтлагдсан өр төлбөр 4 их наяд орчим байна. Компаниудын хоорондын өр төлбөрийг ингээд асуусан. Тэгэхээр энэ өр төлбөрийг би танд тодорхой мэдээлэл өгье. Энэ өр төлбөр ямар өр төлбөрүүд үүсээд байна вэ гэхээр, 4.6 их наяд, үүнээс Тавантолгой төмөр замд 2.1 их наяд, Тавантолгой түлшид 1 их наяд, МТЗ-д 1.3 их наяд тэгээд нөгөө эрчим хүчний компанийн Шивээ-Овоо, Багануур 2-т ингээд бага, бага 10, 10 гаруй орчим тэрбумын ийм өр үүссэн байгаа. Ингээд нийлэхээрээ нийтдээ 4.6 их наяд. Ер нь бол мэдээж хэрэг энэ компанийн зүгээс сая Бат-Эрдэнэ гишүүд ч нэлээн ярьж байна.

Мэдээж хэрэг ТУЗ шийдвэр гаргах учраас бид нар энэ дээр ингээд шууд тэд эдийг олго гэдэг шийд гарах юм энэ хуулийн асуудал бас байна гэж үзсэн. Ер нь ингээд тодорхой хувийг олгох шийдвэр гарсан тохиолдолд энэ төрийн компанийн өр ширийг хооронд нь суутгаж, өмнө нь хүчээр Засгийн газар элдэв газар тогтоол шийдвэр гаргаад ингээд өрүүд үүсгэчихсэн.

Тийм учраас хэрэв ингээд ноогдол ашиг их хэмжээ хуваарилсан шийдвэр гаргаад, төрд хуваарилах юм бол энэ компани ингээд дампуурна. Ямар ч төлбөрийн чадваргүй болно. Өөрөөр хэлбэл Компанийн тухай хуулийн 47.1.1-д заасан заалт хангагдахгүй, энэ компани бол бүрэн дампуурах болж байгаа юм. Тийм учраас л бид нар ажлын хэсэг дээр олон удаа ярьж байгаа. Хэрэв хуваарилсан тохиолдолд энэ өмнө нь бас л төр засгийн шийдвэрүүдээр гараад компани дээр өрийн дарамт үүсгэж байгаа асуудлыг нь бас шийдэх нь зүйтэй гэсэн заалт оруулаад өгье.

Ингэсэн тохиолдолд бол нэгдүгээрт цаашидаа энэ компанийн дарамтаас гарна, цаашидаа ноогдол ашиг нь ард иргэдэд хуваарилах асуудлын хувьд ч гэсэн байдал сайжирна. Хоёрдугаарт энэ жил хуваариллаа ч гэсэн энэ компани өөрөө төлбөрийн чадваргүй болох энэ эрсдэлийг бид нар бас харах ёстой гэж ингэж үзсэн байгаа. Тэгээд ер нь энэ сүүлд ажлын хэсэг дээр яригдсан, өөрчлөгдсөн заалтууд бол Мягмар даргын яриад байгаа баахан хууль зөрчсөн гээд анхны тогтоол дээр холбоотой л дүгнэлтүүд уншаад байх шиг байна л даа. Тэгээд үүнтэй холбоотой энэ яригдсан эрсдэлүүдийг бүгдийг нь ингээд цэгцлээд, ямар нэгэн хуулийн эрсдэлгүй байдлаар засаж оруулсан гэдэг зүйлийг бас дахин давтаж хэлэхийг хүсэж байна.

Ц.Цэрэнпунцаг: Хариулт хангалттай гэж үзэж байх шиг байна. Ингээд Ундрэм гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрэм: Энэ асуудал манай Эдийн засгийн байнгын хороон дээр маш олон удаа яригдсан. Тэгээд манай Байнгын хорооны гишүүд олон ч тогтоолын төслийг энэ асуудалтай холбоотой гаргаж байсан. Тэгээд үүний үндсэн дээр хамгийн олон нийтэд шаардлагатай байсан 2012 оноос хойш төрсөн 1 сая орчим хүүхдүүдэд 1072 хувьцаа олгохоор ийм тогтоолын төсөл болж ингэж орж ирж байгаад маш их баяртай байна. Гэхдээ бид нар цаашид бас энэ гишүүд хэлж байна л даа. Компанийн удирдлага Засгийн газарт бас нэмж хэлэх ёстой, энд протоколд тусгуулах ёстой. Нэгдүгээрт энэ ноогдол ашгийг ард иргэдэд олгох талаар бас гишүүд хэлж байна.

Дээрээс нь энэ эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал байгаа. Ер нь бол хувьцаа гэдэг бол хувь хүний өмч байх ёстой. Тэгээд ардчилсан нийгмийн хамгийн бас тулгуур нэг үзэл санаа бол төр, нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрнө гэсэн ийм үзэл баримтлал байдаг. Тэгээд яг өмчилж эдийн засгийн эргэлтэд оруулна гэдэг чинь хэрвээ нас барах юм бол өвлүүлэх асуудал байгаа. Дээрээс нь үүнийгээ бас эдийн засгийн эргэлтэд оруулж зарах арилжаалах энэ асуудал байгаа. Мөн магадгүй иргэд хувьцаагаараа нийлж хөрөнгө оруулалтын сан байгуулах боломж байж болно гэх мэтчилэн ийм асуудлууд байгаа.

Тэгэхээр энэ баялгийн сангийн хуульдаа эдгээр асуудлыг оруулж ирэх, мэдээж ард иргэдийнхээ энэ хувьцааны ханишийн хэлбэлзлээс сэргийлгээд доод үнийн механизмыг хэрэглэж, хувьцааны үнийг 933 төгрөгөөс унахгүй байх асуудлууд ч байдаг юм уу гээд маш олон талыг нь харж, Баялгийн сангийн хуулиа боловсруулаасай, боловсруулах ёстой шүү гэж бас та бүхэнд хэлмээр байна. Тэгээд Баялгийн сангийн хууль одоо ингээд чуулган хаах гэж байдаг тэгээд хаврын чуулган цагаан сарын дараа

эхэлнэ. Тэгээд үүнийг бол яаралтай өргөн барьж, яаралтай бид нар батлах ёстой. Цаашид одоо бид нар ингээд нэг цэгцлээд авч байна шүү дээ 2012 оноос хойш төрсөн хүүхдүүдийн асуудлыг. Ингээд дахиад 24 он гараад, дахиад өчнөөн хүүхдүүд төрөөд эхэлчихсэн байгаа. Тэгэхээр энэ хуулиараа бид нар шинээр төрсөн иргэдийг нь яах юм, нас барсныг нь яах юм гээд бүгдийг нь зохицуулахгүй бол дахиад л шинээр проблем асуудлууд, ойлгомжгүй байдлууд хуримтлагдаад явна гэдгийг та бүхэн мэдэж байгаа байх. Тэгэхээр үүнийг нэг мөр энэ Баялгийн сангийн хуулиараа бид нар зохицуулах ёстой. Тал талаас нь бодох ёстой шүү.

Энэ тогтоол гарсны дараа бол Эрдэнэс Тавантолгой компанийн тайлан аудитаар хянагдаад удирдах зөвлөл нь хуралдаад, тэгээд тодорхой бас иргэддээ ноогдол ашгийг бол олгоно гэж ойлгож байгаа. Мөн төрд олгогдох ашгаасаа энэ өөрийн өр төлбөрийг ч гэсэн бас төлөөд явах нь зүйтэй гэж бодож байна.

Ц.Цэрэнпунцаг: Ундрэм гишүүн санал хэлчхэв үү. Тийм ээ дандаа санал хэлчихлээ. Угаасаа энэ Их Хурлын тогтоол бол яг энэ хууль гарахтай холбогдуулаад үүний өмнө хуулиа гаргахын тулд цэгцэлж, бэлтгэл ажлын хүрээнд хийгдэж байгаа ажил гэж ойлгож болох юм байгаа шүү энэ хууль. Батлут гишүүн асуултаа асууя.

Д.Батлут: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Байгалийн баялаг, ард түмний өмч, байгалийн баялгаас ард иргэд маань ижил тэгш хувь хэмжээгээр ашиг шим хүртэж байх ёстой гэж өнгөрсөн хугацаанд бүгдээрээ их л ярилаа. Тэгээд гарч байгаа шийдлүүд нь цаг үеийн шинэ чанартай шийдлүүд гараад үндсэндээ тооцоо судалгаагүй юм хийгдээд явж байгаагийн хүндрэлүүд нь өнөөдөр ингээд гарч ирээд байгаа юм л даа. 2011 билүү, 2012 онд билүү Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцаанаас авсан хүмүүс маань сургалтын төлбөрөө

төлсөн, эрүүл мэндийн үйлчилгээ авсан бараг 700-гаад мянган хүн байгаа. Ингээд харахлаар зарим нэг нь авч болоод байдаг, зарим нэг нь авч болохгүй байгаа. Нөхцөл байдлууд үүсчихсэн байна гээд.

Тэгэхээр бид нар нэлээн тооцоо судалгаатай асуудалд хандмаар санагдаад байгаа юм. Би бол энэ байгалийн баялгаас иргэд маань ашиг шимийг тэгш хүртээмжтэй хүртэх ёстой гэдэг тал дээр бол зогсож байгаа хүн. Тэгэхдээ тооцоо судалгаатай өнөөгийн нөхцөл байдалд тулгуурласан ирээдүйн нөхцөл байдлыг тооцсон хэлбэрээр асуудалд хандах нь зүйтэй гэж харж байна. Тэгэхгүйгээр явах юм бол магадгүй бид нар өнөөдөр 500 мянган төгрөгийг иргэн болгонд өгч байгаа нэртэй баахан инфляц хөөрөгдөөд, тэгээд дээрээс нь нөгөө наймаа хийдэг хүмүүс маань дундаас нь завшаад, яг эцсийн бүлэгт үр дүн байхгүй. Ард иргэддээ амьдралд нялзсан нялзаасан зүйлгүй л хоцорчих вий гэж болгоомжилж байгаа.

Тийм учраас энэ дээр маш болгоомжтой хандмаар байна. Тэр төрсөн хүүхдүүдийг, ирээдүйд төрөх хүүхдүүдийг хэрхэн тооцох юм. Нас барсан тохиолдолд өмчлөх, нөгөө өвлөгдөх асуудлыг яаж оруулах юм гээд хуультайгаа нийцүүлсэн олон талт арга хэмжээг судалж, шинжилж, тооцож, гаргаж ирж байж энэ асуудалд хандах ёстой гэж харж байгаа юм. Тэгэхгүй бол яг түрүүний хэлдэг үр дүнгүүд нөлөөт гараад ирэх вий. Урьд нь бид нар дандаа ингэсэн бас л тийм асуудлууд үүссэн. Жишээлбэл тэтгэвэр нэмэгдүүлсэн. Монгол Улсын Засгийн газраас, Их Хурлаас хөрөнгө Биржийн тухай хууль гаргаж хэрэгжүүлж эхэлснээс болоод нүүрсний үнийг бид нар нэлээн өндөрт зарж борлуулдаг болсон. Түүнээс олсон ашиг орлогоороо бид нар тэтгэврийн хэмжээг нэмсэн. Яасан инфляц хөөрөгдчихсэн. Дараа нь очоод иргэдтэй уулзалдъя гэхээр, тэр тэтгэврийн чинь нэмэгдэл юм болсонгүй хүүхээ гээд сууж

байгаа шүү дээ хүмүүс. Ийм дүр зургууд ахиад бий болгочих вий. Тэгэхээр нэлээн судалгаатай, суурьтай эргээд энэ байгалийн баялаг нь ард иргэддээ яг очсон ашиг шимийг нь хүртсэн хэлбэр лүү орж өгөх нь зүйтэй гэж харж байгаа юм. Асуултууд давхцаж байгаа. Тэгэхдээ яах вэ, өнөөдөр энэ Тавантолгой компани чинь ноогдол ашгаа өгөх юм бол санхүүгийн чадамж нь байгаа юм уу.

Одоо энэ тогтоолын төслийн 4.1 дээр байгаа бусад төрийн оролцоотой ААН-үүдийн хооронд үүссэн өр авлагыг суутган тооцно гэхчхэн. Тэгээд дээрээс нь бүх иргэдэд ноогдол ашиг өгнө. Энэ чинь яг хэдэн төгрөг болоод байгаа юм. Яг үүнийгээ бид нар давж туулаад цаад талд нь энэ компани чинь үйл ажиллагаа явуулах боломжтой үлдэх юм уу. Манай Монгол Улсад 2, 3 төрийн өмчит ААН-үүд үнэхээр гайгүй ашигтай ажиллаж байна гэж харж байгаа шүү дээ. Бусдыгаа чирч яваа яг үнэндээ. Ингээд бүх юманд аваачиж оруулж хөрөнгө оруулалт хийсээр байгаад татаад унагачих юм уу. Энэ нь бид нарт ашигтай байгаа юм уу. Бодох л хэрэг шүү дээ, бүгдээрээ. Энэ дээр нэг хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт нь, энэ тогтоол гарснаараа хууль хооронд зөрчил үүсэх гээд байгаа асуудлууд байна. Мягмар даргын танилцуулсан тэр зөрчлүүд. Үүнийг бид нар яаж зохицуулах юм бэ. Яг үнэндээ түрүүн миний хэлдэг тооцоотой судалгаатай хууль эрх зүйн орчныг нь зөвөөр бүрдүүлж байж энэ асуудалд хандахгүй бол болохгүй байгаа. Тэгээд тогтоол гардаг, хууль эрх зүйн зөрчлүүд бий болчихсон байдаг ингээд эргээд гацаанд орчих юм биш биз дээ нөхөд өө? Энэ дээр надад нэг тайлбар өгөөч. Тухайлбал иргэн бүрийн.

Ц.Цэрэнпунцаг: Батлут гишүүн 2 асуулт асуулаа. Нэг дэх асуултад 4 номер хариулах юм уу Наранцогт захирал аа, тодорхой хариулчих. Ямар хэмжээний бололцоо байгаа юм, түүний

хэдэн хувь нь ашиг хуваарилалтад явах юм, хэдэн хувь нь тэр өр авлагыг суутгаад тооцох юм. Ямар харьцаатай байгаа юм бэ гэж асууж байна. Түүнийг нь хариулчхаарай. Ажлын хэсгийн 4 номер хариулъя.

С.Наранцогт: Батлут гишүүний асуултад хариулъя. Бас түрүүн Ундрам гишүүн ч гэсэн үгэндээ хэлсэн. Тэгэхээр 2 төрлийн юмыг гишүүддээ зөв, ажлын хэсэг дээрээ ч гэсэн бид нар нэлээд ярьсан. Ер нь цай цаашидаа энэ тогтвортой газрын баялгаас орох үр өгөөжийг ард иргэд, өнөө ирээдүйдээ хуваарилах тухай асуудал бол нэг асуудал. Энэ бол Баялгийн сангийн хууль дээр тодорхой туссан. Тэгээд ярьж байгаа инфляцтай холбоотой асуудал нь нэгдсэн төсвийн нэг хэсэг болоод тухайн жилийн макро орчинтойгоо уялдуулж явна гээд их нарийн зохицуулагдсан асуудал.

Эрдэнэс Тавантолгойн хувьцаа хуваарилах тухай асуудал энэ өөрөө 2010 онд 39 дүгээр тогтоол гаргаад энэ Тавантолгой компанийн тодорхой хэсгийг хувьчилсан. Бараг хувьчлалын хэлбэрийн л асуудал. Нэг талдаа ингээд давуу эрхийн хувьцаа юм шиг өгчихсөн хэрнээ нөгөө талдаа байхгүй. Тэгэхээр энэ дээр энгийн хувьцаа болгож бүртгэж байгаагаараа бол Ундрам гишүүний түрүүний ярьж байгаа энэ яг бодитойгоор хувьцаа болж хувирах, энэ нөхцөл байдал бол бүрдэж байгаа гэж ингэж ойлгох ёстой юм.

Хоёрдугаар асуудал нь, энэ жил компанийн яг аудитлагдсан нэлээн засвар ордог шүү дээ. Аудитлагдсан тайлан эцэслээгүй, аудит эцэслээгүй байгаа учраас яг тодорхой тоо бол гарахад хэцүү байгаа. 2 илүү, 3 орчим их наядын цэвэр ашигтай ажиллах болов уу. Үүний тодорхой хувийг хувьцаа хэлбэрт шилжүүлэхээр нэг хүнд 200 мянга орчим төгрөг хуваарилагдах болов уу гэдэг ийм зүйл байгаа. Гэхдээ Компанийн тухай хуулийн 47.1.1-д заасны дагуу ноогдол

ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх ёстой. Тэгэхээр бид нар энэ асуудлыг ярьж байгаад үнэхээр ард иргэддээ аль болох ноогдол ашгийг нь хуваарилах нь зүйтэй, хувьцаа эзэмшигчиддээ. Энэ тохиолдолд компанийн санхүүгийн хүндрэлийг хэрхэн яаж шийдэх вэ гэдэг тал дээр үзээд тэр 3 дугаар заалтыг оруулж ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл түрүүний миний уншсан 4.6 их наяд төгрөгийн компаниудын хоорондын өр төлбөр үүсчихсэн байгаа юм. Энэ төлбөртэй суутган тооцох юм бол компани өөрөө төрд ноогдох ноогдол ашгаа бэлэн мөнгөөр тараахгүй. Өмнө нь ингээд төр засгийн шийдвэрээр гарч үүссэн өрүүдээ цэгцлээд ер нь энэ компаниудын хувьд ч тэр, Тавантолгойн хувьд ч тэр, цаашидаа энэ ноогдол ашиг хуваарилахад ч гэсэн их чухал зүйл болж өгөх юм. Энэ 3 дугаар заалт. Тэгээд үүнийг бид нар бас тооцоо судалгаа гэж таны хэлж байгаа үүнийг хийж л энэ зүйлийг гаргаж ирсэн.

Хууль эрх зүйн зөрчил гээд таны 2 дугаар асуулт гарлаа. Мягмар даргын хэлсэн баахан тэр хуулийн зөрчлийн ярьсан асуудал тодорхой хэмжээнд байгаа. Түүнийг нь ингээд цэгцлээд одоо ажлын хэсэг дээр янзлаад цэгцлээд оруулж ирж байгаа энэ тогтоолууд дээр бол ямар нэгэн хуулийн зөрчил бол байхгүй. Харин тэр Үндсэн хуультай холбоотой тэр хуулиар зохицуулах энэ тэр гээд баахан юм яриад байгаа нь 2 асуудлаа хольж хутгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиар яасан байгалийн баялаг ашиглалттай холбоотой үр өгөөжийг одоо болоод ирээдүйд эрх тэгш хуваарилах гэдэг асуудлыг бол Баялгийн сангийн хуульд угаасаа бид нар тусгаад ингээд төслөө бэлдчихсэн байгаа. Энэ асуудал. Энэ хувьцаа хуваарилах асуудал бол 2010 онд Улсын Их Хурлын тогтоолоор л шийдэгдсэн, түүнээс хойш 10, 15 тогтоол гаргаад ингээд сэглээд янз бүр болгочихсон юмыг өнөөдөр Баялгийн сангийн хууль тогтолцоогоо бүрдүүлэхийн өмнө хүн болгон тэгш

эрхтэй өнөөдөр амьд сэрүүн байгаа иргэдэд энэ хувьцаа тараах гэдэг асуудал байдаг учраас яг тэр өмчийн хэлбэрийн хувьцааг нь өгөөд энэ асуудлаа хаагаад, дахин ийм үнэгүй компанийн засаглалын түрүүн бас хуулийн юун дээр ч гарч байлаа шүү дээ. Компани өөрөө хувьцаа гаргах тухай асуудлыг л ярих болохоос биш цаашид ингэж хувьцааг үнэгүй олгодог асуудлыг үүгээр бас нэг мөр цэгцэлж хааж явах ёстой. Баялгийн сангийн хуулийг дагаж мөрдөх хуулийн төсөл дээр ч энэ асуудал ингээд тусгагдсан байгаа. Тэгэхлээр өнөөдөр байгаа иргэдийн энэ хувьчилсан асуудлыг тэгшитгээд тэгээд цаашидаа бол тогтолцоогоо бүрдүүлээд явах юмаа гэж.

Ц.Цэрэнпунцаг: Мягмар дарга гүйцээгээд бас тодруулаад хариулчих уу?

Саяын тэр таны хийсэн дүгнэлтүүд дотор чинь хууль зөрчигдсөн гээд байгаа асуудлууд маань энэ тогтоол дээр байгаа эсэх талаар Батлут гишүүн асууж байна. Хариулъя ажлын хэсгийн нэг номер.

Н.Мягмар: Батлут гишүүний асуултад тодруулж хариулъя. Бид бүхний энэ Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газраас гаргасан эрх зүйн дүгнэлт дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн анхны төсөлтэй холбоотой дүгнэлтүүдийг нь танилцуулж байгаа. Энэ маань Эдийн засгийн байнгын хорооноос Монгол Улсын Үндсэн хууль болон Компанийн тухай хууль, Иргэний хуультай зөрчилдсөн эсэх гэдэг ийм чиглэлийг бол ирүүлсэн албан бичиг дээрээ эрх зүйн дүгнэлтийг гаргах хүрээ хязгаарыг тогтоож өгсөн байж байгаа. Эрх зүйн дүгнэлт гаргах тусгай журамтай ХЗБХ-ноос баталсан журамтай. Тэгэхлээр бидний гаргасан дүгнэлтэд нэгдүгээрт энэ төслөөр ирээдүйд төрөх хүүхдүүд болох харьяат болох улсуудад бас энэ хувьцааг хугацаагүйгээр ингээд эзэмшүүлэхээр зохицуулалтыг тусгаж

үзэл баримтлалын төсөлд орж ирсэн нь Үндсэн хуулийн байгалийн баялгаас олох орлогыг ирээдүй ба хойч үедээ олгох асуудал баялгийн сангаар дамжиж явна гэсэн нь Үндсэн хуулийн энэ зарчимтай чинь зөрчилдөөд байна. Тийм учраас энэ хуулийн хүрээнд энэ нэг асуудлыг авч үзэж шийдэх ёстой болохоос биш энэ баялгийн үр өгөөжийг хувьцааны хэлбэрээр бүх иргэдэд ирээдүйд хүргэгч болон харьяат болох улсууд эзэмшүүлэх бас байдлаар шийдвэрлэх нь Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу гаргаж өгсөн, Засгийн газарт өгсөн чиглэлтэй нийцэхгүй байна гэдэг хамгийн гол дүгнэлт гарч ирж байгаа.

Хоёрдугаарт, энэ хувьцаа өөрөө түрүүн бас ярилаа. Эдийн засгийн эргэлтэд орж амилах ёстой. Энэ хувьцааны зохицуулалттай энэ тогтоол маань өөрөө бас зөрчилдөх нь. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигчийн бүртгэлээс нас барсан юм уу, харьяатаас гарсан тохиолдолд хасахаар ингэж зохицуулж байгаа нь хувьцааны мөн чанар болох өмчлөх эрхэнд халдсан ийм хуулийн зохицуулалттай зөрчилдөөд байна гэдэг үндсэн гол санаа эндээс гарч ирж байгаа юм.

Ц.Цэрэнпунцаг: Батлут гишүүн тодруулж асууя.

Д.Батлут: Тэгэхээр яах вэ. Тогтоол гарлаа ч гэсэн хууль тогтоомжийн хүрээнд бас магадгүй хуулиас илүү давсан тогтоол гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр хуулийн хүрээнд гарах ёстой гэж харж байгаа. Тэгэхээр магадгүй бид нар тогтоол гаргадаг, саяын энэ мэтчилэнгээр хуулийн зөрчилтэй гэж үзээд ямар нэгэн байдлаар ҮХЦ-д ханддаг ч юм уу ямар нэгэн асуудал үүсвэл бид яах вэ гээд ингээд гацаанд орох гээд байна шүү. Тэгэхээр энэ гарц гаргалгаагаа аягүй сайн бодмоор байгаа юм бүгдээрээ. Их зөв талаас нь харж зохицуулалтуудыг нь хийж, тэгээд энэ тогтоолын төсөлд хандахгүй бол өнөөдөр энэ тогтоолын

төсөл маань тун ач холбогдол муутай тогтоол болно. Тогтоол болж батлагдана. Тэгэхээр энэ дээрээ бүгдээрээ нэг анхаараач. Магадгүй ингээд энэ Улсын Их Хурлын хуулийн газрын дарга болон энэ хүмүүстэйгээ зөвшилцөж байгаад ажлын хэсгийн дарга нэг шийдэл дээр энэ өөрчлөлтүүдээ хийх боломж бололцоо байгаа юм уу. Тэгэхгүй бол яг үндсэндээ хууль зөрчсөн шийдэл гарах гээд байна шүү дээ.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 4 номер нэмээд хариулчих.

С.Наранцогт: Батлут гишүүний асуултад тодруулж хариулъя. Мягмар дарга бол сая маш тодорхой хариуллаа шүү дээ. Анх оруулж ирсэн төсөл дээр ажиллаад угаасаа нөгөө дүгнэлт гаргах журмынхаа дагуу анхны төсөл дээр нь ажилласан. Тэгээд анхны төсөл дээр яг гарсан юмнуудыг нь бид нар бүгд ажлын хэсэг дээр залруулж засаад тогтоол чинь тэр чигээрээ өөрчлөгдөөд ингээд зарчмын саналууд хураагдаад ингээд ороод ирсэн. Түүнийхээ дагуу одоо санал хураагдана гэж бид нар ойлгож байгаа. Одоо бол хууль эрх зүйн зөрчил үүсэхгүй. Яг таны ярьж байгаа хувьцаа чинь яг хувьцааныхаа хэлбэрт шилжснэ байгаа.

Ц.Цэрэнпунцаг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Ингээд ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулъя.

Зарчмын зөрүүтэй 6 санал байна.

Ингээд тогтоолын төслийн нэг дэх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншъя.

Нэг.Тогтоолын төслийн нэг дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1/ Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааг холбогдох хууль

тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын нийт иргэдэд адил тэнцүү хэмжээгээр эзэмшүүлэх чиглэлээр дараах арга арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Т.Доржханд, Ч.Ундрэм, С.Энхтүвшин, М.Оюунчимэг, Х.Ганхуяг /цаашид “ажлын хэсэг” гэх/.

Санал хураалт. Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ.

Бат-Эрдэнэ гишүүн дэмжиж санал өгсөн боловч энэ төхөөрөмж ажиллаагүй байна шүү. Протоколд тэмдэглээрэй.

2. Тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1/2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн болон харьяат болсон Монгол Улсын иргэн бүрд Эрдэнэс Тавантолгой ХК-ийн 1072 ширхэг энгийн хувьцааг эзэмшүүлэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг.

Санал хураалт. Гишүүдийн 81.8 хувиар дэмжиж санал дэмжигдлээ.

3. Тогтоолын төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2/Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүйгээр олгосон Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааг тус компанийн энгийн хувьцаанд бүртгэх.

Санал гаргасан: Ажлын хэсэг.

Санал хураалт. Гишүүдийн 81.8 хувиар дэмжиж санал дэмжигдлээ.

4. Тогтоолын төслийн 1 дэх заалтын 3 дахь дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3/ Эрдэнэс Тавантолгой ХК-ийн эрх бүхий этгээд ноогдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ноогдох хувьцааны ноогдол ашгийн орлогоос Эрдэнэс Тавантолгой ХК, Эрдэнэс Монгол нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой ААН-үүд хооронд үүссэн өр авлагад суутган тооцох.

Ганхуяг гишүүн асуулт асууя.
Санал хэлье.

Х.Ганхуяг: Санал хураалтын энэ заалт дээр нэг жсоохон эргэлзээтэй санагдаад байгаа юм. Нэгдүгээрт ноогдол ашгийн хэмжээг бид нар өнөөдөр тодорхойлох боломжгүй байна. Баялгийн сангийн хуулийг орж ирэхээр энэ асуудлыг ноогдол ашигтай холбоотой асуудал хэлэлцэнэ гэж байгаа юм. Тэгэхээр яг нөгөө төрийн өмчид оногдох төрд оногдох ноогдол ашгийн хэмжээ нь тодорхой бус байна. Дээрээс нь энэ компаниудын ямар, ямар өр авлагыг нь аль, аль өр авлагыг нь ямар хэмжээнд гаргах гэж байгаа нь тодорхой бус байна. Тэгэхээр ийм бүдүүн бараг ийм томъёоллоор ийм том асуудлыг ингээд нэг доор шийдээд явчхаж болохгүй болов уу гэж зарчмын байр суурьтай байгаа юм.

Хоёрдугаарт, яагаад гэхээр Эрдэнэс Монгол гэдэг компани чинь нэг концессоор байсан авто замыг өөр дээрээ өмчлөлөөр буюу зээлээр авсан байдаг. Тэгээд зээлийнх нь төлбөрөө төлдөггүй нэг ийм асуудал бас яригдаж л байсан. Тэгэхээр бид нар энэ ямар зээлийг ямар өр авлагыг яах гэж байгаа юм, ямар мэдээлэл байгаа юм, тэр мэдээллийг нь харж байж ийм шийдвэр гаргахгүй бол зүгээр ингээд авсан ашигаараа өр авлагаа хооронд нь тооцож болно гэдэг ийм шийдвэр гарахад арайхан эрт юм болов уу гэж ийм бодолтой байна даа.

Ц.Цэрэнпунцаг: Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээе. Наранцогт захирал хариулъя.

С.Наранцогт: Би түрүүн таны асуултад хариулахдаа зүгээр ер нь үүсчихсэн байгаа өр төлбөрийн асуудлуудыг нэг бүрчлэн хэлчихсэн. Том дүнгээс нь дахиад хэлье. Тавантолгой төмөр зам 2.1 их наяд байна, МТЗ 1.3, Тавантолгой түлшид 1 их наяд гээд нийтдээ 4.6. Тэгэхээр Их Хурал дээр мэдээж энэ компанийн доторх зүйлийг ярихгүй нь бол яах вэ, энэ эрхийг нь олгочихсон тохиолдолд иргэдэд ноогдол ашиг хуваарилах тухай ойлголт бий болж эхэлнэ. Энэ тогтоолын заалт байхгүй бол иргэдэд ноогдол ашиг хуваарилах ямар ч боломжгүй. Энэ компани өөрөө санхүүгийн ямар ч чадваргүй, өр төлбөрийн чадваргүй болоод ингээд дампуурна, бүрэн дампуурна.

Тэгэхээр энэ дээр бид нэгэнт ийм өр төлбөр өмнө нь ингээд төр засгийн шийдвэрээр гаргаад компани өр төлбөрт орчихсон байна. Үүнийг нь төрөөс хэрэв олгосон тохиолдолд гэж байгаа шүү дээ. Ингээд энэ юмыг тооцож байж иргэдэд ноогдол ашиг олгох бололцоо бүрдэх юм байна гэж ингэж ярьсан. Түрүүний тэр ярьсантай холбогдуулаад замын 275 тэрбумаар Гашуунсухайт замыг Хөгжлийн банкны зээлээр авсан. Энэ өр төлбөрийг бид нар өнгөрсөн нэг жилийн хугацаанд ажиллахдаа өрийг нь бүрэн барж, Хөгжлийн банкны зээлийг хаасан.

Энэ талаар бас бид нар албан мэдээлэл өгсөн. Эрдэнэс Монгол өөрөө нэг их өр ширэнд байхгүй. Энэ жилийн үед Эрдэнэс Монгол татварын дараа хуримтлагдсан 201 тэрбум төгрөгийн өрийг төлөөд, татварын өмнө 244 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байгаа. Бид нар санхүүгийн хувьд энэ компанийг бүрэн хөл дээр нь жилийн дотор бол босгож чадсан гэдгийг хэлмээр байна.

Эрдэнэс Монгол компанид ямар ч өр эндээс суутгагдахгүй.

Ц.Цэрэнпунцаг: Наранцогт захирал Ганхуяг гишүүн таны асуултад бас товчхон хариулчихлаа. Ер нь ажлын хэсгээс гарсан энэ санал дээр гишүүд ойлголтоо нэгтгэчих ёстой юм байгаа. Яг энэ гаргасан санал дээр Наранцогт захирал аа, ийм ойлголттой байгаа шүү дээ.

Өнөөдөр энэ Эрдэнэс Тавантолгой ХК ашиг хуваарилахад энэ заалтыг оруулж өгч байж өнөөдөр энэ компани алиныгаа дивидендээр хуваарилах юм. Алиныг өрөнд суутгаж тооцох юм. Өнөөдөр ихэнх харилцагчид чинь дандаа төрийн өмчтэй компаниуд байгаа биз дээ. Нөгөө компаниуд тэр хэдэд бас энэ өр ширнийх нь асуудлыг шийдэж бас зохих хэмжээнд бүрэн дараагийн жил ажиллах, үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бололцоог нь хангаж өгөхийн тулд бол энэ компанид бас өөрт нь ажиллах маневр хийх ийм орон зай гаргаж өгч байгаа гэж ойлгож, энэ зүйл заалтыг ажлын хэсэг оруулж ирсэн юм байна гэж байгаа юм.

Тийм учраас энэ томьёоллоор ойлгож байгаа. Ингээд энэ дээрээ санал хураалт явуулъя. Үүнийг нь би дэмжиж өгөх нь зүйтэй байх гэж бодож байна.

Санал хураалт. Гишүүдийн 81.8 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

5. Тогтоолын төслийн 1 дэх заалтын 4 дэх дэд заалтыг төслөөс хасах.

Санал хураалт.

Гишүүдэд төсөл байгаа. Энэ чинь Үндсэн хууль зөрчсөн гээд Батлут гишүүний санаа зовоод байгаа зүйлийг эндээс хасаж байгаа юм шүү. Зөрчилдөөд байгаа нөгөө асуудлуудыг, орж ирсэн төсөл дээр байсан.

Гишүүдийн 72.7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Батлут гишүүн дэмжих санал өгсөн. Протоколд тэмдэглээрэй.

6. Тогтоолын төслийн 2 дахь заалтыг төслөөс хасах.

Санал гаргасан. Ажлын хэсэг.

Санал хураалт. Гишүүдийн 81.8 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

“Эрдэнэс Тавантолгой ХК-ийн хувьцааны талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Ингээд тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, Ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр уншиж танилцуулна.

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж дууслаа.

15.48 цаг

Байнгын хорооны хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

Энэ ажлын хэсгийнхэнд бүгдэд нь баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ